

Мэдээллийн нууцыг “Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 22 дугаар зүйлийн дагуу хадгална.

Үндэсний статистикийн газар батлав
2006 он Тушаал № 01/32

Улсын тайлан маягт ХУ-1а

**ХУДАЛДАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
..... оны-р САРЫН МЭДЭЭ**

Регистрийн дугаар							
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Байгууллагын нэр							
Үйл ажиллагааны салбарын чиглэл							

1. Аж ахуйн нэгж, байгууллагууд **сар бүрийн 2-нд 1,3,4-р мөрийг**, 1, 4, 7, 10-р сарын 2-нд бүх үзүүлэлтээр гарган сумдын засаг даргын тамгын газар, дүүргийн статистикийн хэлтэст
2. Сумдын тамгын газар, дүүргийн статистикийн хэлтсээс **сар бүрийн 3-нд 1,3,4-р мөрийг**, 1, 4, 7, 10-р сарын 3-нд бүх үзүүлэлтээр гарган аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт ирүүлнэ.
3. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар **сар бүрийн 4-нд 1,3,4-р мөрийг**, 1, 4, 7, 10-р сарын 4-нд бүх үзүүлэлтээр гарган электрон шуудангаар ҮСГ-т дамжуулна.

Үзүүлэлт	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Гүйцэтгэл	
			жилийн эхнээс өссөн дүнгээр	тайлант хугацааны
А	Б		1	2
1. Нийт орлого	1	мян.төг		
2.Тайлант хугацаанд борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	2	мян.төг		
3. Ажиллагчдын тоо	3	хүн		
Үүнээс эмэгтэй	4	хүн		
4. Худалдааны ашигтай талбайн нийт хэмжээ	5	м ²	X	
5. Кассын машины тоо	6	ш	X	
Үүнээс: барааны код уншигчтай (сканертай)	7	ш	X	
6. Ажлын цагийн үргэлжлэх хугацаа	8	цаг	X	

Тамга

Захирал (эзэн)

Ерөнхий (ахлах) нягтлан бодогч

Эдийн засагч.....

Утас:

Факс:

Маягт нөхөх товч заавар ХУ-1А

Энэхүү маягтыг худалдаа эрхэлдэг, санхүүгийн тайлан тэнцэл хөтөлдөг, өмчийн бүх төрлийн статистикийн мэдээлэгчид тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж мэдээлнэ.

“Статистикийн мэдээлэгч” гэж статистикийн мэдээлэл судалгаанд хамрагдсан, Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, өмчийн бүх төрөлд хамаарагдах хуулийн этгээд, гадаадад үйл ажиллагаа явуулдаг Монгол улсын хуулийн этгээд, Монгол улсын болон гадаадын иргэн харьяалалгүй хүнийг хэлнэ.

Нийт орлого, ажиллагчдын тоог сар бүр, бусад үзүүлэлтийг улирлаар мэдээлнэ.

1-р мөрөнд Үндсэн үйл ажиллагааны нийт орлогын дүнг тавих бөгөөд энэ нь борлуулалт, түрээсийн, бусад орлогын нийлбэртэй тэнцүү байна.

2-р мөрөнд Тухайн аж ахуйн нэгжийн тайлант хугацааны борлуулсан бараа бүтээгдэхүүний өртгийг тавина. **Борлуулсан барааны өртөг** нь бараа материалын эхний үлдэгдэл дээр худалдан авалтыг нэмж, бараа материалын эцсийн үлдэгдлийг хассан дүн юм.

3-р мөрөнд Тухайн тайлант хугацааны (улирлын/сарын) эцэст байгаа нийт ажиллагчдын тоог бичнэ. Үүнд удирдах ажилтан (захирал, эзэн, инженер зэрэг), ажилчид зэрэг тухайн байгууллагад ажилладаг бүх хүн орно.

5-р мөрөнд Худалдааны ашигтай талбайн нийт хэмжээг м²-аар тооцож тавина. **Худалдааны ашигтай талбай** гэж худалдааны үйл ажиллагаа явагдаж байгаа талбайн хэмжээ юм.

6-р мөрөнд Худалдааны үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа кассын машины нийт тоог бичнэ. Кассын машиныг барааны олон улсын стандарт код уншигч (сканер)-тай, код уншигчгүй гэж 2 ангилал бөгөөд энэ мөрөнд тэдгээрийн нийлбэр тавигдана.

7-р мөрөнд Нийт кассын машинаас барааны код уншигчтай кассын машины тоог сугалж харуулна. Барааны код уншигчтай кассын машин нь барааны код уншигч сканер, компьютер, талон хэвлэгч гэсэн 3 хэсгээс бүрддэгийг анхаарна уу.

8-р мөрөнд Ажлын цагийн үргэлжлэх хугацааг тавина. Энэ нь тухайн худалдааны байгууллагын нээх цагаас хаах цаг хүртэлх нийтэд үйлчилсэн хугацаа байна.

ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

УТАС: 266414